

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт



**“И-МОНГОЛ АКАДЕМИ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

**“И-МОНГОЛ АКАДЕМИ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
Алсын хараа 2050-ийн ХӨГЖЛИЙН БОДЛОГО БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ: Алсын хараа 2050-ийн хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.1, 5.3.2, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.3, ЗГҮАХ-ийн 4.1, МУ-ын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 7.3							
НЭГ. Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой зөвлөгөө, мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөх, төрөөс баримтлах бодлого, чиглэл, шийдвэрийн дагуу хөгжүүлж байгаа үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, хамтын ажиллагааг өргөжүүлэх							
1.1	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем болон хариуцсан бусад системтэй холбоотой иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагаас ирүүлсэн санал хүсэлтийг бүртгэн, өргөдөл, гомдлыг шийдвэрлэнэ.	-	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо	1442	1500	Төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй холбоотой иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагаас ирүүлсэн 1782 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж ажилласан. Дэлгэрэнгүй тайлан- Хавсралт 1	100%
1.2	Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр илгээсэн үйлчилгээний төлбөрийн буцаалттай холбоотой асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгнө.	-	Хүсэлтийг шийдвэрлэсэн тоо	596	200	Төлбөрийн буцаалттай холбоотой 650 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн.	100%
1.3	1111-2 лавлах, дуудлагын системийн тайланд бүртгэгдэж буй дуудлагыг алдагдалгүй авна.	33,000,000	Алдагдалгүй дуудлагын хувь	98%	98%	2025 онд 1111-2 лавлах, дуудлагын системд ирсэн дуудлагыг 98% алдалгүй хүлээн авч шийдвэрлэсэн. Дэлгэрэнгүй тайлан-Хавсралт 1	100%

1.4	Иргэд, олон нийтэд төрийн үйлчилгээний нэгдсэн систем болон хариуцаж буй бусад системийн талаарх видео мэдээллүүдэд дохионы хэлмэрчтэй хамтран хүргэнэ.	19,600,000	Контентын тоо	-	30	Контентын тоо: 19 Иргэд, олон нийтэд төрийн үйлчилгээний нэгдсэн систем болон хариуцаж буй бусад системийн талаарх видео мэдээллүүдэд дохионы хэлмэрчтэй хамтран 3 рийл, 1 постер, 13 видеог хүргэсэн байна. Энэ жил нийт 30 контент хийх байсан боловч дохионы хэлмэрч ажлаасаа гарснаас үүдэн тоон үзүүлэлттэй хүрч чадаагүй. 2025.12.31-ны өдрөөс өмнө энэ жилдээ багтааж 12 контент хийхээр төлөвлөн ажиллаж байна. Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	63%
1.5	Дуудлагын төвийн хүртээмжийг сайжруулж, сонсголын бэрхшээлтэй иргэдэд дохионы хэлээр зөвлөгөө, мэдээлэл хүргэнэ.	-	Зөвлөгөө, мэдээлэл өгсөн тоо	-	500	Зөвлөгөө, мэдээлэл өгсөн тоо: 415 Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	83%
1.6	Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлнэ.	-	Системд бүртгэлтэй хэрэглэгчийн тоо	1,932,313	2,100,000	2,087,342	99%
1.7	Олон нийтийг байгууллагын үйл ажиллагааны мэдээллээр хангаж, таниулах үйл ажиллагааг зохион байгуулна.	-	Нийтлэгдсэн мэдээний тоо	80	90	2025 онд нийт 197 мэдээг тухай бүрт нь www.ema.gov.mn , www.gov.mn , www.e-mongolia.mn вэб сайтуудад нийтэлж ажилласан. Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	100%
1.8	Цахим шилжилтийг зохион байгуулж буй төрийн болон бизнесийн байгууллагуудтай хамтран ажиллана.	-	Байгууллагын тоо	57	60	Цахимжуулсан үйлчилгээнүүдийг иргэд, олон нийтэд таниулан сурталчлах чиглэлээр нийт 310 байгууллагатай хамтарч ажилласан. Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	100%
1.10	Төрийн цахим үйлчилгээг авах заавар бүхий цуврал контент бэлтгэж, түгээнэ.	19,000,000	Контентын тоо	100	128	Контентын тоо: 130 Нийт 30 заавар бүхий рийл, 64 постер, 36 видео зааврыг хийж сошиал сувагт байршуулсан. Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	100%
1.11	Байгууллагын албан ёсны нийгмийн сүлжээг хөтлөн мэдээ, мэдээлэл түгээнэ.		Постын тоо	160	190	Постын тоо: 532 Сошиал сувгаар үйлчилгээтэй холбоотой 400 постер, 5 ковер постер, баярын мэндчилгээний 10 постер, үйлчилгээтэй холбоотой 97 рийл, E-Mongolia порталын онцлох үйлчилгээний баннер	100%

						20 ширхгийг байршуулсан. Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	
1.12	Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулна.	-	Олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээлэл	100	100	Нийтийн мэдээллийн ил тод байдлын шилэн үнэлгээний тайланг улирал бүрийн товлосон хугацаанд тасралтгүй хүргэж, холбогдох мэдээллийг байнга шинэчлэн, цаг тухай бүр байршуулан ажиллаж байна. Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 3	100%
1.13	Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд мэдээлэл хүргэнэ.	-	Контентын тоо	-	10	Уг ажлын хүрээнд 10 төрлийн мэдээллийг бэлтгэн байгууллагын албан ёсны цахим хуудас, веб сайт мөн E-Mongolia аппликэйшн болон порталд байршуулж, олон нийтэд хүргэсэн. Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	100%
1.14	Байгууллагын дотоод хэм хэмжээ, журмуудыг дахин шинэчилж, боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулна.	-	Шинэчилсэн журмын тоо	-	3	Байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх 3 журам, 1 дүрэм шинээр баталсан. Үүнд: - Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, ажлын гүйцэтгэл, биелэлтийг үнэлэх, шагнал, урамшуулал олгох журам, - Албан хэрэг хөтлөлт, бүртгэл, хяналтын журам - Систем ашиглалтын журам - Архивын дүрэм Гадаад сургалт, томилолт, арга хэмжээг зохицуулах журам, Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журмууд нийт 11 журмыг шинэчлэн баталсан.	100%
Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.11, 5.3.12, 5.3.13, 5.3.17, 5.3.21, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.3.3, 5.3.4, ЗГҮАХ-ийн 4.3.1, 4.3.2.4, МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 4.1.2, Цахим үндэстэн баримтлах чиглэлийн 2.1.1, 2.1.3, 2.2.3, 5.2.4, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөний 2.8, 2.9;							
ХОЁР. Цахим шилжилтийн стратеги, төлөвлөгөөний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, шинээр нэвтрүүлэх мэдээллийн технологийн төслийг салбарын бодлого, төлөвлөлт, стандарттай нийцүүлэх санал, зөвлөмж гаргах, ажлын даалгавар, техникийн нөхцөл боловсруулах							
2.1	Монгол Улсын хиймэл оюун ухааны стратегийн баримт бичгийн төсөл боловсруулан ЦХИХХЯ-д хүргүүлнэ.	-	Төслийн тоо	0	1	Монгол Улсын хиймэл оюуны үндэсний стратеги /2025-2030/ төсөл боловсруулах ажлыг удирдан гүйцэтгэж ЦХИХХЯ-нд хүргүүлсэн. Уг төсөл нь зөвхөн И-Монгол академи УТҮГ-ын	100%

						мэргэжилтнүүдийн туршлага дээр үндэслэн гаргасан санал, төсөл юм.	
2.2	Орон нутгийн төрийн байгууллагуудаас ирүүлсэн саналын дагуу орон нутгийн зарим үйлчилгээг цахимжуулна.	-	Үйлчилгээний тоо	100 /2024 онд нэвтрүүлсэн/	39 /25 онд нэвтрүүлнэ/	2025 онд орон нутгийн нийт 33 үйлчилгээг цахимжуулсан. Энэ онд орон нутагаас өөр цахимжуулах үйлчилгээний санал ирүүлээгүй болно. Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	85%
2.3	Орон нутгийн үйлчилгээнүүдийг дахин инженерчилж, бүрдүүлбэрийг ижил болгоно.	-	Үйлчилгээний тоо	30	26	Орон нутгийн 15 үйлчилгээнүүдийг дахин инженерчилж, бүрдүүлбэрийг ижил болгосон. Бусад бүрдүүлбэр ижил болгох үйлчилгээ дээр үйлчилгээ хариуцагч байгууллагууд бүрдүүлбэрээ баталгаажуулж өгөөгүй байна. Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	58%
2.4	Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргана.	-	Зөвлөмж, дүгнэлт гаргасан тоо	15	20	2025 онд нийт 12 системд зөвлөмж, дүгнэлт гаргаж ЦХИХХЯ руу илгээсэн. Энэ онд төрийн бусад байгууллагаас зөвлөмж дүгнэлт гаргуулах санал ирүүлээгүй Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	60%
2.5	Төрийн байгууллагын цахимжилт, системийн сайжруулалт, нөхцөл байдлын судалгаа хийнэ.	-	Судалгааны тоо	7	5	Төрийн байгууллагын цахимжилт, системийн сайжруулалт, нөхцөл байдлын 5 судалгаа хийж ажилсан. Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	100%
2.6	Тодорхой салбар, байгууллагын цахим системийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллана.	-	Хамтран ажилласан салбар, системийн тоо	12	6	11 байгууллагын цахим системийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажилсан. Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	100%
2.7	Төрийн бусад байгууллагуудтай хамтарч Цахим шилжилтийн талаар хурал, зөвлөгөөн, арга хэмжээ зохион байгуулна.	-	Судалгааны тоо	2	1	Төрийн бусад байгууллагуудтай хамтарч Цахим шилжилтийн талаар 7 хурал, зөвлөгөөн, арга хэмжээ зохион байгуулсан. Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	100%
2.8	Төрийн үйлчилгээний нэгдсэн системд орсон олон шатлалт	-	Үйлчилгээний тоо	0	50	Төрийн үйлчилгээний нэгдсэн системд орсон олон шатлалт 92 үйлчилгээг дахин инженерчилсэн.	100%

	үйлчилгээг инженерчилнэ.	дахин					Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	
Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт: Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.5, 5.3.11, 5.3.12, 5.3.15, 5.3.16, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.3.3, 5.3.4, ЗГҮАХ-ийн 4.3, МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 4.1.2, Цахим үндэстэн баримтлах чиглэлийн 2.2.1, 2.2.2, 2.3.9, 5.2.4, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөний 2.2, 2.9, 2.11, 2.14;								
ГУРАВ. “Төр, хувийн хэвшлийн дундын мэдээлэл солилцооны систем, түүнийг дэмжих системүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах, хөгжүүлэх” зорилгын хүрээнд								
3.1	ХУР системд мэдээлэл солилцох сервисийг хөгжүүлж тоог нэмэгдүүлнэ.	-	Сервисийн тоо	810	860	916	100%	
3.2	Төрийн үйлчилгээний нэгдсэн системд шинэ үйлчилгээ нэвтрүүлнэ.	-	Үйлчилгээний тоо	0	50	Төрийн үйлчилгээний систем e-mongolia-н бодит орчинд нийт 70 үйлчилгээ хөгжүүлж нэвтрүүлсэн. Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	100%	
3.3	Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн frontend, backend кодын шинэчлэл хийнэ.	-	Кодын шинэчлэл хийсэн системийн тоо	0	1	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем e-mongolia, e-business, хур-api системүүдийн backend код java 8 хувилбараас java 17 хувилбар луу upgrade хийсэн. NODE JS (Next JS) ашиглан порталын frontend кодыг шинээр бичсэн бөгөөд Nextjs 15 frontend framework, програмчлалын хэл typescript, хэлбэржүүлэлт дизайн tailwindcss технологиудыг ашиглан кодын шинэчлэлийг хийсэн. Nextjs ашигласнаар production горимд илүү хурдан, код илүү цэгцтэй болсон. Мөн Үндсэн компонентуудыг дизайн системийн дагуу вариантуудыг хэрэгжүүлснээр кодын давхардал болон хэмжээг бууруулж чадсан. Ерөнхий прожектийн хүрээнд дагаж мөрдөх бүтэц нэрлэлт зэргийг тодорхойлсон convention rule – бичиг баримттай болсон.	100%	
3.4	Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн нэвтрэлтийн шийдлийг боловсронгуй болгоно.	-	Кодын шинэчлэл хийсэн системийн тоо	0	1	Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн нэвтрэлтийг хялбаршуулах нэгдсэн нэвтрэлтийн шийдлийг боловсруулж хөгжүүлэлт хийн бодит орчинд нэвтрүүлсэн. Ингэснээр e-mongolia системийн дэд системүүд болох manage.e-mongolia.mn; service.e-mongolia.mn, operator.e-mongolia.mn системүүдэд e-Mongolia	100%	

						аппликэйшнээр QR code уншуулан хялбар нэвтрэх боломжтой болсон. Мөн Төрийн байгууллага өгөгдөл мэдээллийн control.e-mongolia.mn системд холбож бодит орчинд нэвтрүүлсэн.	
						Файл хадгалалтын архитектур сайжруулан CDN file upload-ийн шинэчлэлийг Төрийн үйлчилгээний систем e-mongolia-н бүх суваг дээр хийсэн. Мөн тус бүрд төлөв хөтлөх болон бусад сайжруулалт оруулсан. Төрийн үйлчилгээний бүрдэл материал авах алхамд PDF Лавлагаа тодорхойлолтыг хавсаргах үйлдлийн оронд системээс автоматаар лавлагаа тодорхойлолтыг үүсгэн үүсгэсэн файлыг шууд ашиглах боломжтой болгосон. Баримт бичгийн бүрдэл шаардлагатай PDF файлыг GSing тоон гарын үсгээр баталгаажуулах боломжтой болсон.	
3.5	Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн лавлагаа, сертификат төрлийн PDF зурах технологийг шинэчилнэ. Файл хадгалалтын системийг сайжруулна.	-	Кодын шинэчлэл хийсэн системийн тоо	0	1	Төрийн үйлчилгээний бүрдэл материал авах алхамд PDF Лавлагаа тодорхойлолтыг хавсаргах үйлдлийн оронд системээс автоматаар лавлагаа тодорхойлолтыг үүсгэн үүсгэсэн файлыг шууд ашиглах боломжтой болгосон. Баримт бичгийн бүрдэл шаардлагатай PDF файлыг GSing тоон гарын үсгээр баталгаажуулах боломжтой болсон.	100%
3.6	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP-г төрийн байгууллагуудад нэвтрүүлнэ.	-	Шинээр ERP нэвтрүүлсэн Байгууллагын тоо	2967	3000	Тайлант хугацаанд тус системийг 263 төрийн байгууллагад нэвтрүүлсэн. Мэдээллийн систем хэрэглэгчийн дэмжлэг үйлчилгээг 3,356 байгууллагад үзүүлж 2025 онд төлөвлөсөн зорилтот үр дүнг бүрэн ханган ажиллалаа. Тус системийн мобайл болон портал хувилбарыг 96,754 хэрэглэгч ашиглаж байгаагаас 66,007 вэб хэрэглэгч, 30,747 мобайл хэрэглэгч байна.	100%
3.7	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-mongolia платформын аппликейшн болон веб сувгуудын 5.0 хувилбарыг хөгжүүлнэ.	-	Хөгжүүлсэн хувилбар	4	5	Төрийн үйлчилгээний систем e-mongolia мобайл болон вэб сувгийн 5.0 хувилбарыг хөгжүүлж, 2025 оны 09 сарын 20-ны өдөр нээлтээ хийн олон нийтэд танилцуулсан. Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	100%

						Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийн портал болон мобайл хувилбарын 2.0 хувилбарыг өмнөх хувилбарын ашиглалтын сайжруулалт, системийн гүйцэтгэл, хэвийн найдвартай ажиллагааг хангах чиглэлд технологийн өргөтгөл хийх, дахин загварчлах чиглэлд төлөвлөн хэрэгжүүлж, үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн.	
3.8	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /ERP/-д портал болон мобайлын 2.0 хувилбарыг хөгжүүлнэ.	-	Хөгжүүлсэн хувилбар	1	2	ЦХИХХЯ-аас 2025.09.24-ний өдөр ирүүлсэн чиглэлийн дагуу тус системийн Өргөдөл гомдлын модульд сайжруулалт, нэмэлт хөгжүүлэлтийг гүйцэтгэж Өргөдөл гомдлын нэгдсэн санд бодит цагаар өгөгдөл нийлүүлэх ажлыг гүйцэтгэсэн. Тус хөгжүүлэлтийн хүрээнд системийн лавлах мэдээллийн өөрчлөлт, тулгалтыг гүйцэтгэж системд Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем ХУР-ын 5 сервисийг холбосон. Системийн хөгжүүлэлт, туршилт, чанарын хяналтыг гүйцэтгэж 2025.11.05-ны өдрөөс эхлэн бодит орчинд нэвтрүүлж, тайлант хугацааны байдлаар 2428 өргөдөл гомдол, 10202 өргөдөл гомдлын төлөвийг тус санд нийлүүлсэн байна. Системийн нэвтрүүлэлтийн хяналтыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх чиглэлд Системүүдийн нэгдсэн хяналтын систем ema-dashboards.mongolia.mn-д өргөдөл гомдлын нэгдсэн санд нийлүүлсэн мэдээллийн хяналтын үзүүлэлтийг тусгаж үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2	100%
3.9	Албан бичиг солилцооны дундын систем (docx)-ийн 2.0 хувилбарыг хөгжүүлнэ.	-	Хөгжүүлсэн хувилбар	2	3	Албан бичиг солилцооны дундын "DocX" системийн 3.0 хувилбарыг хөгжүүлэх ажлын хүрээнд системийн 2.0 хувилбарын хууль эрх зүйн нийцлийн шинжилгээг гүйцэтгэж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 21.1, 21.2 дахь хэсэгт заасан хэрэгжилтийг хангах чиглэлд үйл явцын шинжилгээг гүйцэтгэн бодлогын даалгаврыг 2025.05.09 ЗГХЭГ-т, бодлогын	100%

						даалгаврыг баталгаажуулах ажилд дэмжлэг хүсэж 2025.11.18-нд ЦХИХХЯ-д төрийн цахим шуудангаар тус тус хүргүүлсэн. Бодлогын даалгавар баталгаажиг ирээгүй байна.	
3.10	Засгийн газрын хуралдааны систем /e-cabinet/-ийн портал болон мобайлын 3.0 хувилбарыг хөгжүүлнэ.	-	Хөгжүүлсэн хувилбар	2	3	Засгийн газрын хуралдааны нэгдсэн системийн ашиглалтын сайжруулалт, дэмжлэг үйлчилгээг үзүүлэн ажилласан. Ашиглалтын сайжруулалтын хүрээнд дараах нэмэлт хөгжүүлэлтийг гүйцэтгэж нэвтрүүлсэн. 1. Хэрэглэгчийн эрхийн тохиргооны бодлогын сайжруулалт хийсэн - Шийдвэр харах эрхтэй дүрүүд бие биеэ үгүйсгэж зөв ажиллахгүй байсан асуудлыг засварласан. 2. Тайлангийн модулийн сайжруулалт - Тайлангууд хугацаагаар шүүх боломжийг хөгжүүлж, нэвтрүүлсэн. 3. Шийдвэр - Цахимаар илгээсэн тоог админ болон шийдвэр удирдах эрхтэй дүрд харуулах боломжтой болгосон. 4. Тараалтын хуудас дээр шийдвэр харсан лог үлддэг хөгжүүлсэн. 5. Хэрэглэгчийн эрхийг хүчингүй болох, хүний нөөцийн эргэцийг удирдах боломжийг хөгжүүлсэн. 6. Хэрэглэгчийг устгах үйлдлийг хасаж зөвхөн "чөлөөлөх" үйлдэлтэйгээр үлдээсэн. 7. Шинээр ажилд орсон хүн өмнөх шийдвэрүүдийг харах боломжтой болгосон. 8. Шинээр ажилд орсон хүний шийдвэр харсан лог үлддэг болгож сайжруулалт хийсэн. Тус системийн эзэмшигч ЗГХЭГ-ийн Мэдээлэл, технологийн хэлтсээс системд хийгдэх том хэмжээний өөрчлөлт байхгүй буюу шинэ хувилбар хөгжүүлэх төлөвлөгөөгүй, ашиглалтыг сайжруулах	100%

						чиглэлд ажиллах чиглэлийг төрийн цахим шуудангаар 2025.12.03-нд ирүүлсэн байна.	
3.11	Хариуцсан системүүдэд захиалагч болон хэрэглэгч ирүүлсэн шаардлагатай хөгжүүлэлтийг хийнэ. - docx.gov.mn - erp.e-mongolia.mn - www.gov.mn - e-cabinet.gov.mn - awards.gov.mn - sudalgaa.gov.mn - ema-dashboard.e-mongolia.mn - esign.gov.mn - lavlagaa.e-mongolia.mn - huduu.mn	-	Нэмэлт хөгжүүлэлтийн тоо	-	1	Лавлагаа систем: Тус системд ТЦҮЗГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу “Хил хамгаалах ерөнхий газар”-ын хэрэглэгчийн эрхийг үүсгэж, тус байгууллагад холбогдох 3 төрлийн албан хэрэгцээнд харагдах үйлчилгээг, Албан журмын даатгагчдын холбооны хүсэлтийн дагуу 2 лавлагаа үйлчилгээг хөгжүүлэн үйл ажиллагаанд нэвтрүүлж, Эрүүл мэндийн яамнаас ирсэн хүсэлтийн дагуу 3 төрлийн лавлагааг үйл ажиллагаанаас хассан. Үндэсний судалгааны нэгдсэн платформ - sudalgaa.gov.mn Тайлант хугацаанд тус системийн хэлний хувилбарыг ахиулсан. - Хэрэглэгчийн эрхтэй холбоотой аюулгүй байдлын хөгжүүлэлт хийсэн. - Платформын шинэчилсэн хувилбарыг орчин үеийн контейнержуулсан дэд бүтцэд шилжүүлсэн. - Системийн технологийн хувилбар ахиулах хөгжүүлэлтийн хүрээнд нийт 39 өөрчлөлт сайжруулалтыг хөгжүүлж нэвтрүүлсэн. Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас - e-mongolia.mn/org, төрийн байгууллагын цахим хуудас удирдлагын систем Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудасны шинэ хувилбарыг хөгжүүлэн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн. Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудасны нэвтрүүлэлтийн төлөвлөгөө боловсруулан оролцогч талуудад хүргүүлсэн. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг бодит цагаар хэмжих зорилгоор системийн админ хэрэглэгч, байгууллагын админ	100%

					хэрэглэгч, дээд байгууллагын админ хэрэглэгчдэд системд бүртгэсэн өгөгдөл мэдээллийн бүрэн байдлыг хянах хяналтын самбарыг хөгжүүлэн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн. Shilen.gov.mn системийн API холболтын шинжилгээний ажлын хүрээнд Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн заалтуудыг тулгах, баталгаажуулах ажил ЦХИХХЯ, ТЦҮЗГ-т хүлээгдэж байна. Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудасны нэвтрүүлэлтийн хүрээнд 1882 байгууллагын 1854 системийн хэрэглэгчид дэмжлэг үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Системийн тогтвортой, тасралтгүй ажиллагааг ханган ажилласнаас системд холбогдох өгөгдөл мэдээллүүд бүртгэгдсэн байна. Тус системийн нэвтрүүлэлтийн үйл ажиллагаанд тулгарч буй практик асуудлууд дээр үндэслэн “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас ашиглах журмын төсөл”-д 14 саналыг боловсруулан ЦХИХХЯ-нд 2025.11.10-ны өдөр хүргүүлсэн. Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас gov.mn, төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудасны удирдлагын систем manage.gov.mn GOV.MN-ний хэрэглэгчийн дэмжлэг үйлчилгээг 2468 төрийн байгууллага, 2555 системийн хэрэглэгчдэд үзүүлэн ажилласан байна. Тус системийн ашиглалтын зарим сайжруулалтын санал, системийн гүйцэтгэл, хэвийн найдвартай ажиллагааг хангах үйл явцын үр дүнд тулгуурлан системийн технологийн хувилбар ахиулж, Төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэгтгэх ажлыг гүйцэтгэсэн. Шинэ хувилбар ашиглаж байгаа системийн хэрэглэгчид хуучин системийн	
--	--	--	--	--	--	--

					мэдээллийг ашиглах боломжоор хангаж, системд холбоосыг байршуулсан. Иргэдийн санал, санаачилгыг хүлээн авах Монгол Улсын Засгийн газрын цахим систем Монгол улсын засгийн газрын хуралдааны журмын 4.8 дугаар зүйл заалтыг хэрэгжүүлэх чиглэлд ЗГХЭГ-ийн захиалгаар иргэн санал санаачилга бүртгэх портал, админ хэрэглэгчийн порталыг хөгжүүлэн 2025.09.20-ны өдөр үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. - Хэрэглэгчийн шаардлагад тулгуурлан системийн шинжилгээг гүйцэтгэсэн. Хэрэглэгчээс сайжруулалтын санал, шаардлагыг системийн туршилтын загвар боловсруулан тодорхойлж, баталгаажуулсан. - Танилт нэвтрэлтийн ДАН системийн холболтыг гүйцэтгэсэн. - Системийн туршилтын болон бодит орчныг тохируулсан. - Аюулгүй байдлын туршилт тохиргоог гүйцэтгэж, сайжруулалтыг хийсэн. Нэвтрүүлэлтийн үйл ажиллагааны хэвийн тасралтгүй байдлыг ханган ажилласнаар 186 иргэний санал санаачилга нийтлэгдсэн байна. Хариуцсан системүүдийн нэвтрэлт, хэрэглэгчийн эрх сэргээх, 2 алхамт баталгаажуулалтад ҮДТ УТҮГ-ийн Үндэсний цахим шуудан - масс мэйл үйлчилгээ, Amazon Simple Email service үйлчилгээг давхар ашиглах замаар хэвийн найдвартай ажиллагаа, ачаалал тогтворжуулах шийдлийг нэвтрүүлсэн. Amazon Simple Email service үйлчилгээний үндсэн шаардлагад тохирууланн системээс илгээж байгаа	
--	--	--	--	--	---	--

						хэрэглэгчийн мэйл хаягийн бичвэрийг lower case хэлбэрээр илгээх хөгжүүлэлтийг гүйцэтгэн, бодит орчинд шинэчилсэн.	
3.13	Программ хангамжийн туршилтыг автоматжуулах технологийн шийдлийг нэвтрүүлнэ.	-	Туршилтыг автоматаар хийх технологийн шийдэл нэвтрүүлсэн эсэх	0	1	Хөгжүүлэлтийн кодын ажиллагааг шалгах автомат хэрэгсэл болох Sonarcube-ийг эх код удирдлагын системтэй хамтран ажиллах боломжтой болгож, хөгжүүлэлтийн эх код стандартын дагуу эсэхийг шалгаж оруулдаг болгосон.	100%
3.14	Газрын хариуцсан системүүдэд ачаалал даах чадварын үнэлгээг хийнэ.	-	Үнэлгээ хийгдсэн системийн тоо	2	4	Дээрхи системүүдийн ачаалал даах чадварын туршилт хийв. Үүнд: - DAN V2 - E-mongolia 5.0 - Erp.E-mongolia.mn	100%
3.15	Нэгтгэсэн хяналтын системд ороогүй системүүдийн сервисийг шат дараатай оруулна.	-	Сервисийн тоо	224	250	Шинээр нэвтрүүлсэн хяналтын системүүд "SolarWind" сервер болон сүлжээний төхөөрөмжийг real-time alerts, SNMP monitoring, latency graph, latency graph, topology map зэрэг онцлогтойгоор хянаж, мониторинг хийж байна. "Foglight" MongoDB, PostgreSQL зэрэг ... ширхэг өгөгдлийн сангуудыг query performance хяналт, agent-based мониторинг, DB health check зэрэг онцлогтойгоор тогтмол хянаж байна.	100%
3.16	Системийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлт, хэвийн найдвартай ажиллагааг хангах журамд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн санал боловсруулж, батлуулна.	-	Баримт бичгийн тоо	-	1	Систем хөгжүүлэлт, нэвтрүүлэлт, хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах журмыг шинэчлэх ажлын хүрээнд Мэдээллийн системийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлтийн журмын төслийн боловсруулан санал авах, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн 2025.09.24-ны өдрийн А/81 тушаалаар батлуулсан. Тус журмын агуулгад дараах үзэл баримтлалуудыг тусгаж, зохицуулалтын цар хүрээг нэмэгдүүлсэн. - Төслийн удирдлага, хяналт; - Мэдээллийн системийн хөгжүүлэлт; - Мэдээллийн системийн туршилт, чанарын хяналт;	100%

						- Мэдээллийн системийг бодит орчинд суурилуулах; - Мэдээллийн системийн нэвтрүүлэлт; - Өөрчлөлтийн удирдлагыг хэрэгжүүлэх;	
3.17	Газрын хариуцсан системүүдийн дата-г нэгтгэсэн, бодит цагийн горимтой дашбоард дахь системийн тоог нэмнэ.	-	Системийн тоо	8	9	Системүүдийн нэгдсэн хянах самбарыг хөгжүүлж, нэвтрүүлэн, хэвийн найдвартай ажиллагааг хангах замаар удирдлагыг бодит цагийн мэдээллээр ханган ажиллаж байна. - “И-Монгол Академи УТҮГ”-ын хөгжүүлсэн системүүдийн нэгдсэн хянах самбарын ema-dashboard.e-mongolia.mn нэвтрүүлэлтийн хүрээнд байгууллагын тайлан мэдээ боловсруулах хэрэглэгчид, удирдлага, дээд байгууллагын хэрэглэгчдэд системийн нэвтрэх 7 эрхийг олгож, үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн. - Нэгдсэн хянах самбар ema-dashboard.e-mongolia.mn нь 9 системийн 60 үзүүлэлт, системүүдийн нэгдсэн хянах самбарын 35 үзүүлэлт нийт 95 үзүүлэлт бүхий 10 хяналтын самбараар зохиомжилсон тайланг үндсэн системүүдээс 1 өдрийн хоцрогдолтойгоор тайлангийн хэрэглэгчдэд нийлүүлж байна. - Системийн ашиглалтын сайжруулалтын хүрээнд хурдыг сайжруулах чиглэлд үндсэн өгөгдлийн сангаас rediss тайлангийн баазаар дамжуулан харуулах шийдлийг нэвтрүүлсэн. - Нэгдсэн хяналтын самбарт өгөгдөл нийлүүлэгч системүүд дээр хийгдсэн өөрчлөлтөд тулгуурлан ekids, гадаадын иргэн сервисийг дахин шалгаж холбох хэсгийг гүйцэтгэлээ. - Ашиглалтын хэвийн найдвартай ажиллагааг хангах чиглэлд мэдээлэл нийлүүлэгч системүүдээс rediss бааз руу өгөгдөл хуулах job-ийг хөгжүүлэн, нэвтрүүлэв.	100%

3.18	Систем ашиглалтын журам боловсруулж, батлуулна.	-	Журмын тоо	0	1	И-Монгол академи УТҮГ-ын захирлын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/81 тушаалаар Системийн ашиглалтын журмыг баталсан. Тус журмын агуулгад дараах үзэл баримтлалуудыг тусгаж, зохицуулалтын цар хүрээг нэмэгдүүлсэн. - Тохиргооны удирдлага хэрэгжүүлэх; - Хэрэглэгчийн эрхийн удирдлага хэрэгжүүлэх; - Давуу эрхт хэрэглэгчийн хяналт, баталгаажуулалт; - Мэдээллийн системийн хөрөнгийн бүртгэл; - Гамшгийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг төлөвлөх, турших, хэрэгжүүлэх;	100%
3.19	Хариуцсан системүүдийн нөөц системийг бий болгоно.	-	Нөөц системийн тоо	1	3	Нийлүүлэгчээр шалгарсан компани талаас бараа нийлүүлэлт удааширсантай холбоотой 12 дугаар сарын байдлаар дэд бүтцийн тоног төхөөрөмжүүд угсрагдаж бэлэн болоогүй байна. Нөөц үүсгэх дэд бүтэц бэлэн бус.	100%
3.20	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем e-mongolia-н ухаалаг чатботыг сайжруулах, хиймэл оюун нэвтрүүлэх судалгаа хийнэ.	-	Судалгааны тоо	-	1	Е-Mongolia системийн датаг хэрхэн ухаалаг чатботод сургах талаар судалгаа хийсэн. Үүнд: үйлчилгээ, үйлчилгээний мэдээлэл, авсан үйлчилгээний төлөв явц, зөвлөмж, түгээмэл асуулт хариултын дата зэргийг Gemini API ашиглан RAG хийх, Vector Search болон Action Tools зэрэг технологийг ашиглах боломжийг судалсан. Цаашид Е-Mongolia системд Multi Agent чатботыг хэрхэн интеграци хийх тал дээр судалгаа хийн, Google Agent Development Kit, Langchain, Langgraph, Langsmith зэрэг framework-д судалгаа хийн туршилт хийсэн. Хавсралт 4	100%
3.21	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем e-mongolia-н ухаалаг чатботыг сайжруулж хиймэл оюун ухаанд суурилсан төрийн үйлчилгээний шийдлийг нэвтрүүлнэ.	400,000,000	Нэвтрүүлсэн шийдлийн тоо	-	1	Төсвийн хэмнэлтээс шалтгаалан нээлттэй тендер цуцлагдсан. Ухаалаг демо чатботыг өөрсдөө хөгжүүлсэн. Тухайн чатбот нь дараах боломжуудыг агуулсан: Е-Mongolia системийн лавлагаа авах, авсан лавлагааг цахим шуудан (email) хаяг руу	100%

						илгээх, үйлчилгээ санал болгох, үйлчилгээний ерөнхий мэдээлэл өгөх. E-mongolia ухаалаг чатботын зориулалтын GPU серверийн орчныг бүрдүүлж, тохируулан, staging болон prod орчинд амжилттай нэвтрүүлсэн. Хавсралт 4	
3.22	Төрийн байгууллагын нэгдсэн хуудас gov.mn ухаалаг чатботыг сайжруулах, хиймэл оюун нэвтрүүлэх судалгаа хийнэ.	-	Судалгааны тоо	-	1	Google-ийн Tridorian төлөөлөгч байгууллагатай онлайн уулзалтад оролцож, хэрхэн Google GCP платформ ашиглах болон ухаалаг чатбот хөгжүүлэх талаар мэдээлэл авч танилцсан. Gemma, OpenAI, LLaMA LLM-үүдийг судалсан. Үүнд: RAG, fine-tuning, токений үнэ, мөн GCP Compute Engine серверт байршуулж ашиглах боломжуудыг судалсан. Хавсралт 4	100%
3.23	Байгууллагын хариуцан ажилладаг системүүдийг сайжруулах моделийг судлан туршина.	-	Туршилт хийсэн тоо	-	4	E-Mongolia системийн хэрэглэгчдэд үйлчилгээ санал болгох шийдлийг сайжруулах, мөн шинэ API гаргах ажлыг хийж гүйцэтгэсэн. 2-р шатлалт үйлчилгээний шийдвэрлэлтийг хэрхэн автоматжуулах судалгаа, e-mongolia системийн үйлчилгээнд хэрэгжүүлэх usecase. E-business системийн компани нэр шалгах модель хөгжүүлэлт хийж байна. E-Mongolia платформын өгөгдлийн баазыг Postgres SQL бааз-руу бичих ETL хийсэн. Emon.servicerequest, Ebus.servicerequest хүсэлтийн таблицеудыг real-time sync буюу өөрчлөлтийг цаг алдалгүй Postgres датабааз-д бичдэг болгосон. МАБ журмын лавлах чатботыг GCP-ийн Google Storage, Vertex AI, RAG engine, Google Agent Development Kit ашиглан демо хөгжүүлсэн. E-business шинэ хувилбарт зориулан AWS-ийн гэрээт компанитай 2 удаагийн уулзалт хийн, РОС хийх төлөвлөгөө гаргасан ба E-Business платформд модель ухаалаг чатботыг хэрхэн ашиглах талаар судалж байна.	100%

3.24	Хиймэл оюунд суурилсан төрийн үйлчилгээний хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт тавих шийдэл нэвтрүүлнэ.	-	Нэвтрүүлэлт -ийн тоо	-	1	Хиймэл оюунт агент лавлагаа төрлийн 50 үйлчилгээг боловсруулах, үүссэн лавлагаагаа чатын явцад шууд харуулах болон хэрэглэгчийн гараас оруулсан мэйлээр илгээх боломжтой болсон. Хиймэл оюунт агентаас хэрэглэгч мэдээлэл авах үеийн асуулт, хариултыг боловсронгуй болгосон.	100%
3.25	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP-д нэвтрүүлж болох хиймэл оюунд суурилсан шийдлүүдийн судалгааг хийнэ.	-	Судалгааны тоо	-	1	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагад ашиглагддаг нэгдсэн ERP системийн үр ашиг, автоматжилтын түвшинг нэмэгдүүлэхийн тулд хиймэл оюун ухаанд (AI) суурилсан боломжит шийдлүүдийг тодорхойлж, судалгаа хийсэн.	100%
3.26	Харилцаа холбооны салбарын дэд бүтцийн дашбоард нэмэлт хөгжүүлэлт хийнэ.	-	Нэмэлт хөгжүүлэлт ийн тоо	-	1	https://ema-dashboard.e-mongolia.mn -нд нэмэлт цэс болгон хөгжүүлэн ЦХИХХЯ-нд хүлээлгэн өгсөн. -БТС, байгууллагаар, давтамж, тархац -Аймаг, Хот, Сум, Дүүрэг -Бүртгэлтэй хэрэглэгч, оршин суугаа иргэд -Шилэн кабел эхлэл төгсгөлийн цэг, шөрмөс, багтаамж	100%
3.27	ҮДТ-д одоо ажиллаж байгаа дэд бүтэц төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус гэмтэл саатал болон доголдол үүсэх үед сэлгэн ажиллах нөөц дэд бүтэц бий болгоно.	8.4 тэрбум	Нөөц дэд бүтцийн тоо	-	1	Нийлүүлэгчээр шалгарсан компани талаас бараа нийлүүлэлт удааширсантай холбоотой 12 дугаар сарын байдлаар дэд бүтцийн тоног төхөөрөмжүүд угсрагдаж бэлэн болоогүй байна.	100%
3.28	Дэд бүтцийн суурь үйлдлийн системийн аюулгүй байдлын болон шийдлийн сайжруулалт хийнэ.	602,800,000	Сайжруулал тын тоо	24	36	Байгууллагын хариуцсан 29 нэр төрлийн системийн дэд бүтцэд тухай бүрт сайжруулалтыг хийж байна.Үүнд: - E-Mongolia platform 5.0 - Gov.mn засгийн газрын нэгдсэн цахим хуудас - E-Bussines 2.0 - Egp.e-mongolia.mn төрийн erp - Docx.gov.mn албан бичиг солилцооны систем - ХҮР төрийн мэдээлэл солилцооны систем - E-cabinet - D-gov.mn	100%

						- Төрийн их өгөгдөлийн BigData төсөл	
3.29	ХУР системд мэдээлэл нийлүүлэх хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлнэ.	-	Байгууллагын тоо	4	1	Төрийн мэдээлэл солилцооны системийн мэдээлэл солилцох чадамжийг сайжруулахын тулд Үндэсний дата төвтэй хамтран нийт 2 байгууллагыг шинээр мэдээлэл нийлүүлэгчээр оруулсан. - Хүнсний лавлагаа лаб - Смарт контракт Монголиа ХХК	100%
3.3	Developer.xyp.gov.mn-д чатбот нэвтрүүлж хэрэглэгчдийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлнэ.	-	Нэвтрүүлэлтийн тоо	0	1	Хиймэл оюунт агент ХУР системийн сервист тайлбар өгөх, мэдээлэл гаргах. Хиймэл оюунт агентаас хэрэглэгч мэдээлэл авах үеийн асуулт, хариултыг боловсронгуй болгосон.	100%
3.31	ХУР системийн тестийн орчныг бий болгоно.	-	Нэвтрүүлэлтийн тоо	0	1	ХУР системд мэдээлэл нийлүүлэгч 43 байгууллагын мэдээлэлд зориулсан туршилтын орчинг үүсгэх судалгааг хийж, туршилтын өгөгдөл үүсгэх ажлуудыг гүйцэтгэсэн.	50%
3.32	Төрийн үйлчилгээний нэгдсэн системд блокчейн технологийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нэвтрүүлнэ.	-	Нэвтрүүлэлтийн тоо	0	1	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем e-mongolia мобайл болон вэб сувгийн 5.0 хувилбарыг хөгжүүлж, 2025 оны 09 сарын 20-ны өдөр нээлтээ хийн олон нийтэд танилцуулсан. Тухайн шинэ хувилбар гэрээний систем болох e-gereee.mn цахим гэрээний системтэй холболт хийсэн. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем e-mongolia-н төлбөрийн модул цэсэд дараах сайжруулалт хийсэн. Үүнд: - Регистрийн дугаараар төлбөр төлсөн мэдээллийг тус цэсээс хайдаг болсон. - Төлөлт цаад байгууллага руу илгээгдээгүй үед дардаг "төлөлт илгээх" товчтой болсон. - Төрийн сангийн IBAN руу хөрвүүлэх сервис ашиглан IBAN (International Bank Account Number) нэвтрүүлсэн. - Пос төхөөрөмжийн нэмэлт хөгжүүлэлтийг тест хийж бодит орчинд нэвтрүүлсэн.	100%

3.33	Иргэд Төрийн үйлчилгээний нэгдсэн систем ашиглан төрийн бодлого, шийдвэр гаргалтад цахим хэлбэрээр санал өгөх боломжийг бүрдүүлнэ.	-	Нэвтрүүлэлт ийн тоо	0	1	Төрийн үйлчилгээний систем e-mongolia мобайл болон вэб сувгийн 5.0 хувилбарыг хөгжүүлж, төрийн шийдвэр гаргалтад нөлөөлөх цахим санал хураалт авах модуль хөгжүүлсэн.	100%
------	--	---	------------------------	---	---	---	------

Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт: Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.18 7.5.7, 7.5.10, 7.5.16, 2021-2030 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.1.5, 2.1.43, 2.1.44, 5.4.14, Цахим үндэстэн баримтлах чиглэлийн 4.1.3, 4.1.4, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөний 1.2.2, 1.2.3, 1.2.6 ;

Дөрөв. "Бүх нийтийн мэдээллийн технологийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, хөтөлбөр зохион байгуулах"

4.1	Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг шинэчилж, батлуулна.	-	Батлагдсан хөтөлбөр	1	1	Төрийн албан хаагчдад цахим ур чадвар олгох сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж түүнд нийцүүлэн шинэчлэн сайжруулсан. Боловсруулсан сургалтын хөтөлбөрийг сайжруулахтай холбогдуулан Удирдлагын академи болон Төрийн албаны зөвлөлөөс саналуудыг авч сэдэв, хөтөлбөрийн бүтэц зэрэгт өгсөн саналыг сургалтын хэлтэс дахин ярилцаж, сайжруулсан сургалтын хөтөлбөрийн боловсруулалтыг 98 хувьтай хийж гүйцэтгэсэн. Сайжруулсан Төрийн албан хаагчдын цахим ур чадварын сургалтын хөтөлбөрийг 12 дугаар сарын 22-ны өдрийн дотор батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. Төрийн албан хаагчийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр - Хавсралт 5	90%
4.2	Харааны бэрхшээлтэй иргэдийн технологийн хүртээмжтэй хөтөлбөр сургалтын боловсруулж, батлуулна.	-	Сургалтын хөтөлбөрийн тоо	0	1	2023 онд боловсруулсан Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан хүртээмжтэй технологийн сургалтын хөтөлбөрийг 6 модулийн 12 агуулгыг хүрээнд дахин сайжруулсан. Энэхүү хөтөлбөрийн дагуу 2024 онд гурван удаагийн нийт 18 иргэнийг хамруулсан сургалтын үр дүнд үндэслэн Харааны бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл, технологийн хүртээмжийг сайжруулах	80%

						зорилгоор хүртээмжтэй сургалтын хөтөлбөр боловсрууллаа. - Хөтөлбөрт тусгай хэрэгцээт суралцагчдын онцлогт нийцсэн дижитал хэрэгсэл, программ, сургалтын арга зүйг тусгасан. - Сургалтын агуулгад дэлгэц уншигч, дуу хоолойт программ, товчлуурын хослол ашиглалт зэрэг практик чадвар эзэмшүүлэх хэсгүүд багтсан.	
						- Хөтөлбөрийг боловсруулсны дараа мэргэжлийн байгууллага, хэрэглэгчдийн төлөөлөлтэй хамтран туршиж, санал зөвлөмж авч сайжруулсан. - Одоогоор сургалтын хөтөлбөрийн боловсруулалт 95 хувийн гүйцэтгэлтэй 12 сардаа батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. Харааны бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн технологи ашиглах чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр - Хавсралт 6	
4.3	Иргэд, төрийн албан хаагчдад зориулсан “Хиймэл оюун ухааны сургалтын хөтөлбөр” боловсруулж, батлуулна.	-	Батлагдсан хөтөлбөр	0	1	“Хиймэл оюун сургалтын хөтөлбөр”-ийг зорилтот бүлэг болох иргэд болон төрийн албан хаагчдын хэрэгцээ шаардлагыг баримт бичгийн, агуулгын хүрээний судалгаа хийж, олон улсын ижил төстэй хөтөлбөрүүдийг харьцуулан анхны хувилбарыг боловсруулсан. Боловсруулсан хөтөлбөрийг “И-Монгол академи” УТҮГ-ын захирлын 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/103 тоот тушаалаар батлуулсан. Сургалтын хөтөлбөр- Хавсралт 7	100%
4.4	Цахим ур чадварын чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулна.	-	Дүгнэлт гаргасан эсэх	0	1	Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/197 тоот тушаалаар батлагдсан “Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар”-ын дагуу боловсруулсан иргэд болон төрийн албан хаагчийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулсан. Уг хөтөлбөрийг ХНХСҮСИ-ийн захирал М. Батгэрэл 2024 оны 12 дугаар сарын 26-	100%

					ны өдөр 2024/928 дугаартай "Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн дүгнэлт" гаргаж, мэргэжлийн байгууллага баталгаажуулсан. Дүгнэлтэд: - Сургалтын төвийн нэр: И-Монгол академи" УТҮГ - Ерөнхий чиглэл: Мэдээлэл харилцаа холбооны технологиуд - Төрөлжсөн чиглэл: Мэдээлэл харилцаа холбооны технологиуд - Нарийвчилсан чиглэл: Компьютерын ашиглалт - Мэргэжлийн индекс: 061101 - Мэргэжлийн чиглэл: Хэрэглээний программ - Мэргэшлийн нэр: Компьютерын операторч - Мэргэшлийн түвшин: II - Сургалтын хугацаа: 14 хоног гэж тус тус заагдсан Хөтөлбөр 3 бүлэг, нийт 33 агуулгыг Чадамжийн элемент бүрд ногдох цагийн тоо, Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, Эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага зэрэг бүтэц, шалгуур үзүүлэлтүүдийг тусган Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.12 дахь хэсэгт заасан "Сургалтын хөтөлбөрт тавих шаардлага, сургалтын хөтөлбөрийн загвар"-ын дагуу боловсруулсан. Хөтөлбөрт - o "Цахим засаглал – Төрийн албан хаагч" – 11 агуулга, - o "Цахим иргэн" – 14 агуулга, "ХБИ – МХХТ- хүртээмж"-ийн – 8 агуулгыг тус тус багтаасан болно. Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн дүгнэлт- Хавсралт 8	
--	--	--	--	--	--	--

						Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын агуулгыг шинэчлэн боловсруулах зорилгоор хэлтсийн албан хаагчид гурван удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, сургалтын үндсэн агуулгуудыг эцэслэн баталгаажууллаа. Үүнд: ○ Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн агуулга – нийт 33 сэдэв;	
4.5	Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын агуулгыг шинэчлэн сайжруулж, боловсруулна.	-	Контентын тоо	5	10	○ Төрийн албан хаагчдад зориулсан сургалтын хөтөлбөр – 14 үндсэн сэдвийн хүрээнд 49 дэд сэдэв; ○ Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөр – 6 модулийн 12 агуулга ○ Хиймэл оюун сургалтын хөтөлбөр - 1 модуль 4 дэд сэдэв багтсан болно. Дээрх хөтөлбөрүүдэд үндэслэн нэгж хичээлийн загварыг боловсруулж, төрийн албан хаагч болон харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан, Хиймэл оюун сургалтын хөтөлбөрт багтсан нийт 24 ерөнхий сэдвийг сайжруулан шинэчилсэн. Шинэчилсэн хувилбарын танилцуулга – Хавсралт 9	100%
4.6	Сургалт, үйл ажиллагааг олон нийтэд таниулах контент боловсруулна.	-	Боловсруулсан контентын тоо	10	12	Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зохион байгуулдаг сургалтын талаарх видео контентыг төрийн байгууллагуудтай хамтран 13 удаагийн видео контент, 91 мэдээг фейсбүүк хуудсанд /www.facebook.com/emongolia.academy/, 14 нийтлэлийг олон нийтийн сүлжээнд байршуулсан болно. Контентийн танилцуулга- Хавсралт 10	100%
4.7	Цахим ур чадварын цуврал видео хичээл бэлтгэж, сургалтын платформуудаар түгээнэ.	-	Бэлтгэсэн видео контентын тоо	0	5	Сургалтын хэлтсээс иргэд болон төрийн албан хаагчдад зориулан зохион байгуулдаг цахим ур чадварын сургалтыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Маркетингийн	100%

						хэлтэстэй хамтран сургалтыг видео хэлбэрээр боловсруулж, дараах 5 сэдвийн хичээлийг бэлтгэн боловсруулж олон нийтэд хүргэсэн. Бэлтгэсэн видео хичээлүүдийг E-Mongolia платформын “Цахим сургалт” цэс Sargalt.gov.mn цахим хуудсанд байршуулж, олон нийтэд нээлттэй ашиглах боломжийг бүрдүүлсэн. Мөн сургалтын талаарх мэдээллийг E-Mongolia page хуудсанд нийтэлсэн болно. Видео контентийн тайлан – Хавсралт 11	
4.8	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил, статистик мэдээлэл боловсруулж, түгээнэ.	-	Статистик мэдээлэл боловсруулсан тоо	0	19	2025 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн E-Mongolia систем, дэмжих системүүд болон 2022-2025 оны сургалтын тоон мэдээллийг өдөр, долоо хоног, сар, улирлын давтамжтайгаар боловсруулан олон нийтэд тогтмол хүргэж байна. Тайлант хугацаанд дараах эрдэм, шинжилгээний ажилд оролцсон байна. Үүнд: - “Насан туршийн боловсрол 2.0” олон улсын эрдэм шинжилгээний хурал https://msue.edu.mn/n/r/2984 - МУИС-ийн ШУС-ийн Боловсрол судлалын тэнхимээс зохион байгуулсан Ахисан түвшний оюутнуудын дунд зохион байгуулсан “Иргэдийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийг дээшлүүлэх нь: Насан туршийн боловсролын боломж” сэдэвт өгүүлэл - МУИС-ийн ШУС-ийн нийгмийн ухааны салбарын ахисан түвшний оюутнуудын эрдэм шинжилгээний хуралд “Иргэдийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийг дээшлүүлэх нь: Насан туршийн боловсролын боломж” сэдэвт өгүүлэл, илтгэл - Жил бүр зохиогддог Олон улсын компьютерийн шинжлэх ухаан, боловсролын технологийн симпозиум (ISCSET) нь Герман, Монгол, Хятад, Узбекистаны их дээд сургууль, судлаачдын 10 гаруй жилийн хамтын ажиллагааг дэмжсэн эрдэм	100%

						шинжилгээний 14 дэх удаагийн хуралд Сургалтын хэлтсийн дарга В.Лут-Очир, бусад судлаачидтай хамтрсан өгүүлэл; - ШУТИС-ийн МХТС-ийн Мэдээллийн систем мэргэжлийн диплом хамгаалуулах хурал 2025.06.03-ны өдөр зохион байгуулж, тус ажлын хэсгийг Сургалтын хэлтсийн дарга В.Лут-Очир 2 дахь жилдээ ахалж ажиллаж, 31 системийг танилцуулсан;	
						- “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн зөрчил, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам-2025” ЭШХ Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас жил бүр зохион байгуулдаг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн зөрчил, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам-2024” эрдэм шинжилгээний хуралд Н.Төрбат, В.Лут-Очир, Н.Бурмаа нар хамтран “Төрийн үйлчилгээний нэгдсэн E-Mongolia системийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдал” сэдэвт өгүүллийг бичиж, эмхэтгэлд хэвлүүлсэн; - Кебир гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил: Онол, чиг хандлага Дотоод хэргийн их сургуулиас зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хуралд С.Галсандаш, Г.Тод нар хамтран “Кебир аюулгүй байдалд цахим боловсролын үзүүлэх нөлөө” сэдвээр өгүүлэл бичиж, эмхэтгэл хэвлүүлсэн. Дэлгэрэнгүй тайлан – Хавсралт 12	
4.9	Гарын авлага, товхимол боловсруулж, түгээнэ.	-	Гарын авлага, товхимлын тоо	2	12	Сургалтын хэлтсээс дараах гарын авлага, товхимол, эмхэтгэлд материалуудыг хэвлүүлж, цахимжуулсан болно. Үүнд: - Цахим засаглалын товхимол - “Мэдээллийн аюулгүй байдлын газар” ТБАГУТҮГ-аас эрхлэн гаргадаг “Cybersecurity” сэтгүүлд E-Mongolia системийн талаарх нийтлэл	100%

						- Интерактив ажлын хуудас бэлтгэх liveworksheets ашиглалтын гарын авлага - Интерактив ажлын хуудас бэлтгэх Wizer.me платформын ашиглалтын гарын авлага - Идэвхтэй сургалтын арга kahoot ашиглах гарын авлага - Насан туршийн боловсрол 2.0 олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд “Enhancing citizen’ information8 communication and technology competence: opportunities in lifelong learning” сэдэвт өгүүлэл - Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудсын гарын авлага - байгууллагын админы түвшинд хийгдсэн гарын авлага, - Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудасны удирдлагын системийн гарын авлага - шинэчилсэн хувилбар - Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia 5.0-ын гарын авлага, - Кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил: Онол, чиг хандлага ОУЭШХурлын эмхэтгэл “Кибер аюулгүй байдалд цахим боловсролын үзүүлэх нөлөө” сэдэвт өгүүлэл, - ISCSET 2025 international symposium ‘Enhancing Citizens Infotmation and Communication Technology Competencies: Opportunities for Lifelong Learning сэдэвт өгүүлэл, - “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн зөрчил, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам-2025” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд “Төрийн үйлчилгээний нэгдсэн E-Mongolia системийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдал” сэдэвт өгүүлэл.	
--	--	--	--	--	--	---	--

4.1	Иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулна.	20,000,000	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	1811	5000	Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх захиалгат сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагын хүсэлтээр танхим болон цахимаар зохион байгуулж, нийт 63 удаагийн 137 цагийн сургалтаар 5008 иргэнд хүрч ажилласан. Дээрх бүх сургалтуудаас: - Удирдамж, хөтөлбөр 1 - Асуулга, судалгаа өмнөх 2, дараах 2 - Сургалтын нэгдсэн тайлан 1 гэх мэт бичиг баримтын боловсруулалтыг гүйцэтгэн ажилласан байна. Төрийн албан хаагчийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын удирдамж – Хавсралт 13	100%
4.11	Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулна.	-	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	5420	6900	Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг Төрийн захиргааны төв байгууллага, Төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн ЗДТГ, НТБТ, ЕБС болон бусад газруудтай хамтран 205 удаагийн 422 цагийн сургалтад 9229 танхимаар, 4938 цахимаар нийт 12254 удирдлага, албан хаагчдад хамрагдсан байна. Сургалтаар DOCX системийн ашиглалт, Төрийн байгууллагуудын удирдлагын нэгдсэн ERP-E-MONGOLIA систем, Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас Gov.mn, хиймэл оюунаар контент бүтээх, цахим орчин дахь хүүхэд хамгаалал-E-kids, технологид суурилсан харилцаа, цахим хөгжлийн багц хууль, мэдээллийн аюулгүй байдал, технологид суурилсан харилцаа агуулгуудаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлсэн. Дээрх нийт сургалтуудаас - Удирдамж, төлөвлөгөө 8 - Асуулга, судалгаа- 10 /өмнөх 6 дараах 4	100%

						- Сургалтын нэгдсэн тайлан 51 гэх мэт бичиг баримтын боловсруулалтыг гүйцэтгэн ажилласан байна.	
4.12	Ахмад настай иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулна.	-	Сургалтад хамрагдсан ахмад настай иргэдийн тоо	177	250	Ахмад настай иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 8 удаагийн 12 цагийн сургалтад нийт 258 ахмадуудад хүртээмжтэй, практик аргаар зохион байгуулсан. Сургалтад оролцсон ахмадууд төрийн цахим үйлчилгээг ойлгож, ухаалаг утсаар эмнэлгийн цаг захиалах, лавлагаа мэдээлэл авах зэрэг практик чадварыг эзэмшин, төрийн үйлчилгээнд түргэн шуурхай хандах боломжтой болсон. - СХД-ийн 13-р хороо, БЗД-ийн 42-р хороо, СБД-ийн 18-р хорооны ахмад настай иргэд, - Европын холбооны санхүүжилттэй "Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах замаар цахим оролцоог нэмэгдүүлэх нь (DICE)" төслийн хүрээнд "Сүүн эрчис" төрийн бус байгууллагатай хамтран ахмад настай иргэд, - БЗД-ийн 5 дугаар хороо, 22 дугаар хорооны ахмад настай иргэд E-Mongolia ашигалт сургалтыг зохион байгуулж ахмадын төрийн үйлчилгээг цахимаар авах мэдлэг ур чадварыг дээшлүүлсэн.	100%
4.13	Их, дээд сургуулийн оюутнуудыг цахим ур чадварын сургалтыг зохион байгуулна.	-	Сургалтад хамрагдсан оюутнуудын тоо	260	1500	Их, дээд сургуулийн оюутнуудад зориулсан цахим ур чадварыг нэмэгдүүлэх зорилго бүхий сургалтыг нийт 24 удаа, 44 цагийн үргэлжлэлтэйгээр танхимаар 1886, цахимаар 135 оюутныг хамруулан зохион байгууллаа. Сургалтын агуулгад мэдээллийн аюулгүй байдал, хиймэл оюун ухаан, технологид суурилсан харилцаа, мэдээллийн хүртээмж, цахим засаглал зэрэг орчин үеийн чухал	100%

						чиглэлүүдийг багтааж, оюутнуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн. Энэхүү сургалтад дараах их, дээд сургуулиудын оюутнууд хамрагдсан болно. Үүнд: • Дотоод хэргийн их сургууль • Монгол улсын их сургууль • Үндэсний батлан хамгаалахын их сургууль • Отгонтэнгэр их сургууль • Удирдлагын академи • Глобал удирдагч их сургууль • Өмнөговь аймгийн оюутнууд • Мон-Алтиус дээд сургууль • Сити их сургууль • Рояль Олон Улсын их сургууль Оюутнууд мэргэжлийн хэрэгцээнд нийцсэн цахим хэрэглээний мэдлэг, цахим орчинд аюулгүй харилцах чадвараа сайжруулах зэрэгт суралцсан. Сургалт нь оюутнуудын мэргэжлийн чиглэлд нийцүүлэн мэдээллийн технологийн хэрэглээ, онлайн орчин дахь хамгаалалт, үр ашигтай хэрэглээ зэрэгт төвлөрсөн.	
4.14	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулна.	-	Сургалтад хамрагдсан сурагчдын тоо	984	1500	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 9 удаа, 16 цагийн үргэлжлэлтэйгээр 1506 сурагчдад цахим, болон танхимаар зохион байгуулсан. Сургалтаар мэдээллийн технологи, мэргэжил сонголт, мэдээллийн аюулгүй байдал, Хиймэл оюунаар контент бүтээх зэрэг агуулгаар мэдлэг, ойлголтыг нь нэмэгдүүлсэн. Тухайн хичээлүүд сурагчдад цахим орчинд зөв зохистой оролцох, хувийн мэдээллээ хэрхэн хамгаалах, мэргэжлээ хэрхэн зөв сонгоход нь нөлөөлөх юм. - Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид	100%

						- Шинэ эрин дунд сургуулийн ахлах бүлгийн сурагчид - Мон-Алтиус Ахлах сургуулийн ахлах ангийн сурагчид - Нийслэлийн Ерөнхий Боловсролын 21 дүгээр сургуулийн 86 ангийн сурагчид - Нийслэлийн Ерөнхий боловсролын 161 дүгээр сургуулийн сурагчид - Нийслэлийн Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн сурагчид	
4.15	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулна.	-	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	58	230	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 9 удаагийн 26 цагийн үргэлжлэлтэйгээр 249 иргэнд цахим болон танхимаар зохион байгуулсан. Сургалтаар хүртээмжтэй технологи, мэдээллийн аюулгүй байдал, E-Mongolia системийн ашиглалт ба хэрэглээ, хиймэл оюунаар контент бүтээх зэрэг агуулгыг хүргэсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим орчин дахь оролцоо, мэдээлэлд хандах боломж, бие даан мэдээлэл ашиглах, цахим үйлчилгээнд хандах чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үр дүнтэй сургалт зохион байгуулсан. - Хан-Уул дүүргийн НТСТ болон Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд, - Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд e-mongolia ашиглалт, Хиймэл оюунаар контент бүтээх сэдвүүдээр - Монголын тусгай олимпын хороотой хамтран хөгжийн бэрхшээлтэй иргэдэд e-mongolia ашиглалт - Монголын Хараагүйчүүдийн Үндэсний холбоотой хамтран Харааны бэрхшээлтэй иргэдэд e-mongolia ашиглалт сургалтыг танхимаар зохион байгуулсан.	100%

4.16	Digital.edu.mn вэб сайтыг дахин загварчилж, сайжруулалт хийнэ.	-	Арга хэмжээний тоо	1	1	Digital.edu.mn цахим хуудсаар дамжуулан хэрэглэгчдийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 40 сургалтын мэдээ, 12 видео контент байршуулж, агуулгын хүртээмжийг нэмэгдүүлсэн. Digital.edu.mn цахим хуудсыг хөгжүүлснээр мэдээллийн хүртээмж сайжирч, хэрэглэгчид видео хичээл, мэдээ мэдээллийг илүү ойлгомжтой, хурдан олж авах боломж бүрдсэн. E-Mongolia 5.0 шинэчлэлийн хүрээнд “Цахим сургалт” цэсийг хөгжүүлснээр Digital.edu.mn цахим хуудасд цахим сургалтыг байршуулах шаардлагагүй болсон тул төрийн албаны сургалтын платформ surgalt.gov.mn-д “Цахим ур чадвар” цэсд цахим ур чадварын сургалтын контентуудыг давхар нийтэлсэн. Сайжруулалтын зураг – Хавсралт 14	100%
4.17	Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.	-	Хамтран ажилласан байгууллагын тоо	221	285	Нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр Сургалтын хэлтэс нь 2025 онд төрийн 336 байгууллага, их, дээд, болон ЕБ-ын сургуулийн 18, төрийн бус, иргэний нийгмийн 12, олон улсын 2 байгууллагууд зэрэг нийт 366 байгууллагатай хамтран ажилласан. Дэлгэрэнгүй тайлан - Хавсралт 2 Хамтран ажиллах тухай албан бичгүүд – Хавсралт 15	100%
Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт: Алсын хараа 2050-ийн хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.1, 5.3.3, I үе шат (2021-2030), МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн Зорилт 5.3, МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 4.1, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөний 1.14							
Тав. “Хариуцсан мэдээллийн систем, дэд бүтцийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах, систем, сүлжээ, үйлчилгээнд аюулгүй байдлын шалгалт, шинжилгээ хийж, эрсдэлийг тодорхойлох, байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэх”							
5.1	“И-Монгол академи” УТҮГ-ын мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журмыг хянаж, шаардлагатай шинэчлэлийг хийнэ.	-	Журмын тоо	0	7	Нэгдсэн менежментийн тогтолцооны 1 бодлого, 1 нэр томъёоны лавлах, Мэдээллийн аюулгүй байдлын 7 журмыг шинэчлэн баталж нийт албан хаагчдад танилцуулах сургалт зохион байгуулсан. Танилцуулга – Хавсралт 16	100%

5.2	Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 27001:2022, Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандартыг нэвтрүүлж, гэрчилгээ авах ажлыг зохион байгуулна.	15,000,000	Зохион байгуулсан эсэх	0	1	Олон улсын Afnor байгууллагын магадлан итгэмжлэлтэй ISO 27001:2022, ISO 9001:2015 стандартын гэрчилгээнүүдээ авсан. 2025 оны 12 дугаар сард эхний удаагийн магадлан аудит орохоор бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Стандартуудын сертификат - Хавсралт 17, 18	100%
5.3	Өөрийн хариуцдаг эрсдэл өндөртэй системүүдэд аюулгүй байдлын шалгуулж, эрсдэлийн үнэлгээг хийлгэж, дүгнэлт гаргуулна.	120,000,000	Дүгнэлт гаргасан системийн тоо	12	22	21 систем шалгасан. Төсөв татагдсан тул зөвхөн өөрсдийн дотоод нөөц бололцоогоор шалгасан.	90%
5.4	Байгууллагын сүлжээний аюулгүй байдлыг сайжруулах шийдлүүд хэрэгжүүлнэ.	-	Хэрэгжүүлсэн байдал	0	1	СНГ-ын зүгээс хэрэгжүүлж газар хэлтэс бүр тусдаа сүлжээтэй болсон. Microsoft Windows 10 албан ёсны дэмжлэг дуусаж Security update хийгдэхгүй болсонтой холбоотой windows 11 руу 2 төхөөрөмж шилжүүлсэн. Байгууллагын хэмжээнд Вот болсон нийт 10 компьютер форматалж, дата файлуудын хор код нуугдсан эсэх шалгаж, хэрэглэгчийн нууц үгийг солих арга хэмжээ авсан.	100%
5.5	Байгууллагын нийт болон шинээр ажилд орсон албан хаагчдыг хамруулсан мэдээллийн аюулгүй байдлын сургалт, дотоод хэм хэмжээг танилцуулах сургалт, албан хаагчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулна.	-	Сургалтын	5	8	Нийт ажилтны сургалтыг 2 удаа, шинэ ажилтны сургалтыг 6 удаа, нийт 8 сургалт зохион байгуулсан.	100%
5.6	Албан хаагчдын МАБ-ын ур чадварыг сайжруулах төлөвлөгөөт ажлууд зохион байгуулна.	-	Судалгааны мэдээллийн тоо	50	100	Алба хаагчдын КАБ мэдлэг чадварыг сайжруулах чиглэлээр нийт 50 гаруй сурталчилгааны хуудас бэлдэж цахим шуудан, ERP сувгуудаар хүргэсэн. Дэлгэрэнгүй тайлан – Хавсралт 19	100%
5.7	Стандартын аудитын дүгнэлтээс авах арга хэмжээ болон стандартын нийцлийн ажлыг зохион байгуулна.	-	Хэрэгжүүлсэн ажлын тоо	-	9	Стандартын аудитын дүгнэлтээс авах арга хэмжээ болон стандартын нийцлийн ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдаж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа хэрэгжүүлж байна.	100%

						Ажлын хэсгийн тушаал – Хавсралт 20 Нэгдсэн менежментийн тогтолцооны стандаруудын магадлах аудитад бэлтгэх төлөвлөгөө – Хавсралт 21	
ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ: Алсын хараа 2050-ийн хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.4.4, 4.5.8, 4.5.12, Цахим үндэстэн баримтлах чиглэлийн 7.1; Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөний зорилт 1.1.1, 1.1.2							
ЗУРГАА. “Байгууллагын албан хаагчдын гадаад арга хэмжээг зохицуулах, гаднын зочид төлөөлөгчдийг хүлээн авах, байгууллагын үйл ажиллагааг олон улсад сурталчлан таниулах, гадаадын салбарын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлага судлах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах”							
6.1	Байгууллагын гадаад арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан, холбогдох журмын дагуу зохион байгуулна.		Батлагдсан баримт бичгийн тоо	0	10	“И-Монгол академи” УТҮГ-ын 2025 оны гадаад томилолт, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, байгууллагын захирлаар 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр батлуулсан ба төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гадаад албан томилолт, арга хэмжээнд хамрагдсан 10 албан хаагчид хамрагдаж Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Техник, Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (ИТЕС)-аас зохион байгуулж буй сургалтуудад дараах 4 албан хаагчид амжилттай хамрагдсан. Түүнчлэн, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Техник, Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (ИТЕС)-аас тус улсад зохион байгуулагдаж буй ээлжит сургалтуудад “И-Монгол академи” УТҮГ-ын албан хаагчдыг хамруулах, байгууллагаас санал болгох ажлын хүрээнд 24 албан хаагчдын тодорхойлолт, шаардагдах материалыг бүрдүүлж илгээсэн. Дэлгэрэнгүй тайлан- Хавсралт 22	100%
6.2	Гадаадын зочид, төлөөлөгчдийг хүлээн авах,	-	Зохион байгуулсан арга	0	2	Тайлант хугацаанд нийт 5 байгууллагын 26 зочин, төлөөлөгчийг хүлээн авч, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлага	100%

	холбогдох арга хэмжээг зохион байгуулна.		хэмжээний тоо			солилцох чиглэлээр уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулан ажилласан. Дэлгэрэнгүй тайлан- Хавсралт 22	
						Байгууллагын хөгжүүлсэн, гадаад зах зээлд экспортлох боломжтой систем, бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулан сурталчлах зорилгын хүрээнд 30 нүүр бүхий иж бүрэн Англи хэл дээрх танилцуулгын эхийг боловсруулж, нийт 200 хувь хэвлүүлэн бэлтгэв. Мөн 41 нүүр бүхий англи хэл дээрх цахим танилцуулгыг боловсруулан, дараах олон улсын арга хэмжээнд оролцон сурталчилгаа хийж, холбогдох байгууллагуудад хүргүүлэв. Үүнд:	
6.3	Байгууллагын цахим танилцуулга, холбогдох материалын агуулгыг англи болон бусад хэл дээр боловсруулж, бэлтгэнэ.	-	Боловсруулсан материалын тоо	0	2	- Австрали Улсын Канберра хотноо зохион байгуулагдсан “Өгөгдлийн интеграцийн семинар” - Камбож Улсад зохион байгуулагдсан “Төрийн үйлчилгээнд хиймэл оюун ухаан ашиглах семинар” - БНХАУ-ын Шанхай хотноо болсон “Хятадын олон улсын импортын долдугаар экспо” - Казахстан Улсын Алматы хотноо зохион байгуулагдсан “Цахим Алматы – 2025” арга хэмжээ Эдгээр арга хэмжээний үеэр байгууллагын үйл ажиллагаа, хөгжүүлсэн шийдлүүд, олон улсын хамтын ажиллагааны чиглэлүүдийг таниулан сурталчилсан болно. Дэлгэрэнгүй тайлан- Хавсралт 22	100%
6.4	Олон улсад санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, нэвтрүүлэх, хамтран ажиллах саналыг хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн саналын тоо	0	10	НҮБ-ын Цахим засаглалын хөгжлийн индекс (EGDI)-ийн үзүүлэлтээр Монгол Улсаас доогуур үнэлгээтэй 143 орныг хамарсан судалгаа хийж, боломжит зах зээл, хамтын ажиллагааны	100%

						чиглэлийг тодорхойлсон ба судалгааны үр дүнд тулгуурлан, нийт 20 гаруй улсад хамтран ажиллах албан ёсны санал хүргүүлсэн бөгөөд дараах улс орнуудтай хамтын ажиллагааг эхлүүлэн, санамж бичгийн төсөл солилцох, туршлага хуваалцах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 7 улстай ажилласан.	
						Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Тажикстан Улсад төрийн байгууллагуудын цахимжилтыг эрчимжүүлэх, цахим үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад дэвшилтэт мэдээллийн технологийн шийдлүүдийг нутагшуулах туршлага солилцон ажиллах, мөн тус улсын цахим засаглалын дэд бүтцийг шинэчлэх, олон улсын үзүүлэлтийн нэг болох EGDl (Цахим засаглалын хөгжлийн индекс)-ийн зэрэглэлийг ахиулах чиглэлд зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр зорьж байна. Дэлгэрэнгүй тайлан- Хавсралт 22	
6.5	Олон улсын салбарын байгууллагуудад гишүүнчлэлээр элсэнэ.	-	Гишүүнчлэл ийн тоо	0	1	Олон улсын 13 байгууллагын (KOICA, JICA, IMF, UNDP, UNICEF, FAO, UNFPA, WHO, OECD, ADB, APEC, World Vision, Дэлхийн Банк, Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага - МХХТ-ийн ажлын хэсэг, Европын Холбоо - Цахим засаглалын төслүүд, Цахим засаглал хэрэгжүүлэгчдийн холбоо) чиг үүрэг, хамтран ажиллах боломжийг судалж, хөрөнгө оруулалт татах суурь судалгаа хийсэн. Судалгаа нь гишүүнчлэл, санхүүжилтийн нөхцөл, түншлэл хөгжүүлэх чиглэлд төвлөрсөн бөгөөд одоогоор хамтран ажиллах, гишүүнчлэлийн эрх авах талаар ажлуудыг төлөвлөж байна. Мөн олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU)-ийн D секторын "Цахим хөгжлийн инноваци ба бизнес эрхлэгчдийн холбоо"-нд гишүүнээр элсэх талаар танилцуулга бэлтгэж, "И-Монгол	50%

						Академи" УТҮГ-ын захирал Б.Мягмарнаран-д танилцуулан 2025 оны 11 сарын 10-ний өдрийн 01/451 тоот албан бичгээр ЦХИХХЯ-д гишүүнээр элсэн орох тухай хүсэлт илгээсэн. Дэлгэрэнгүй тайлан- Хавсралт 22	
6.6	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-г олон улсад зохион байгуулагдаж буй арга хэмжээнд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.	-	Оролцсон арга хэмжээний тоо	1	2	Нийт 5 олон улсад зохион байгуулагдаж буй арга хэмжээнд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан. Дэлгэрэнгүй тайлан- Хавсралт 22	100%
6.7	Олон улсын салбарын байгууллагуудтай санамж бичиг, гэрээ хэлэлцээр байгуулж, түүний хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Байгуулсан гэрээ хэлэлцээрийн тоо	1	2	2025 оны 02 дугаар сарын 01-ний өдөр "Цахим Алматы - 2025" форумын үеэр "И-Монгол академи" УТҮГ болон Бүгд Найрамдах Узбекистан Улсын UZINFOCOM байгууллагын хооронд хиймэл оюун ухаан (AI), хамтарсан сургалт, туршлага солилцох чиглэлээр байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг (MoU)-ийг байгуулсан. Энэхүү санамж бичгийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. - Бүгд Найрамдах Узбекистан Улсын төрийн үйлчилгээг цахимжуулах үүрэг бүхий UZINFOCOM байгууллагатай хийсэн Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах үүрэг бүхий тушаалын төсөл боловсруулж, "И-Монгол академи" УТҮГ-ын захирлын 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/23 тоот тушаалаар батлуулсан; - Санамж бичгийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж тус байгууллагын	100%

						Гадаад харилцааны газрын дарга Баходир Курбонов-д 2025 оны 03 сарын 13-ны өдөр цахим хаягаар илгээсэн. Тус төлөвлөгөөний дагуу хамтын ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөж байна. Мөн тус байгууллагатай 2025 оны 04 сарын 28-ны өдөр цахим уулзалт зохион байгуулж цаашдын хамтын ажиллагааг ханган ажиллаж байна. 4. Монгол Засгийн газрын 100 хоногт шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 04 тоот албан даалгаврын дагуу Япон Улсын Автомашины Үнэлгээний Хүрээлэн болох (JAAI), "JEVIC" ХХК болон "Бюроу Веритас Инспекшэнь Тестинг Монголиа" ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй "Импортын өмнөх техникийн хяналтын үзлэг" үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох E-Mongolia платформоор дамжуулан иргэн, аж ахуйн нэгжид цахим хэлбэрээр үнэ төлбөргүй олгох үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Харилцагч байгууллага болох JAAI "Японы Автомашины Үнэлгээний Хүрээлэн", "JEVIC" ХХК болон "Бюроу Веритас Инспекшэнь Тестинг Монголиа" ХХК талаас хамтран ажиллах саналтай бөгөөд гарын үсэг зурахад бэлэн байгаа талаар манайд албан ёсоор мэдэгдсэн. Ажлын явцад дараах албан бичгүүдийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Үүнд: - 2025.08.12 – 01/347 – Мэдээлэл хүргүүлэх тухай;	
--	--	--	--	--	--	---	--

						- 2025.08.13 – 01/348 – Мэдээлэл хүргүүлэх тухай; - 2025.09.12 – 01/375 – Үүрэг чиглэл авах тухай; - 2025.11.25 – 01/472 – Гэрээний төсөл батлуулах тухай. Тайлант хугацаанд “Импортын өмнөх техникийн хяналтын үзлэг” үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia платформоор нэвтрүүлэх бэлтгэл ажлыг бүрэн хангаж, хамтын ажиллагааны гэрээг олон улсын гурван байгууллагатай тохиролцон баталгаажуулсан. Дэлгэрэнгүй тайлан- Хавсралт 22	
Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт: Алсын хараа 2050-ийн хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 7.5.3, 7.5.8;							
Долоо. “Байгууллагаас санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад нэвтрүүлэх; төрийн зарим үйлчилгээг хувийн хэвшилд шилжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр тус тус судалгаа хийх; байгууллагын бүх төрлийн статистик тоон мэдээллийг нэгтгэж мэдээллийн сан үүсгэх”.							
7.1	Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг олон улсад нэвтрүүлэх, хамтран ажиллах чиглэлээр судалгаа хийнэ.	-	Судалгааны тоо	-	5	НҮБ-ын Цахим засаглалын хөгжлийн индекс (EGDI)-ийн үзүүлэлтээр Монгол Улсаас доогуур үнэлгээтэй 143 орныг хамарсан судалгаа хийж, боломжит зах зээл, хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлсон ба судалгааны үр дүнд тулгуурлан, нийт 20 гаруй улсад хамтран ажиллах албан ёсны санал хүргүүлсэн бөгөөд дараах улс орнуудтай хамтын ажиллагааг эхлүүлэн, санамж бичгийн төсөл солилцох, туршлага хуваалцах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллаж байна. • Бүгд Найрамдах Киргизстан Улс • Камбожийн Хаант Улс • Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс • Бүгд Найрамдах Серби Улс • Бүгд Найрамдах Узбекистан Улс	100%

						Бүгд Найрамдах Казахстан Улс Цаашид хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэн, цахим засаглалын хөгжлийн туршлагыг хуваалцах, дижитал шийдэл экспортлох, зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр олон улсын түвшинд тогтвортой хамтран ажиллахыг зорин ажиллаж байна. Дэлгэрэнгүй тайлан- Хавсралт 22	
7.2	Ф-Регистртэй гадаадын иргэдэд зориулсан төрийн үйлчилгээний хэрэглээ болон туршлагын талаар судалгаа хийж, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.	-	Судалгааны тоо	-	1	Ф-регистертэй гадаадын иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор голлох чиглэлүүдийг нэгтгэсэн нэг цонхны цахим платформ хөгжүүлэх суурь судалгаа хийж, олон улсын туршлагад үндэслэн demo интерфэйс, агуулгын бүтэц, хамтын ажиллагааны загвар, үйл ажиллагааны бүдүүвчийг боловсруулсан. Тус судалгааг Дани, Эстони, БНСУ, Сингапур, Исланд улсуудын туршлагыг харьцуулан судалж, үндсэн шаардлага, чиглэлүүдийг тодорхойлон судалгааны ажлыг боловсруулсан. Судалгааны удирдамж – Хавсралт 23	100%
7.3	Төрийн байгууллагуудад нэвтэрсэн болон нэвтрүүлэхээр төлөвлөж буй хиймэл оюун ухааны шийдлүүдийн судалгааг зохион байгуулна.	-	Судалгааны тоо	-	1	Төрийн байгууллагуудад нэвтэрсэн болон нэвтрүүлэхээр төлөвлөж буй хиймэл оюун ухааны шийдлүүдийн судалгааны ажлын даалгаврыг боловсруулж, судалгааны ажлын хэсэгт ажилласан. Энэ судалгааны ажлын хүрээнд Монгол улсад Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад хиймэл оюун ухааны шийдлүүд хэрхэн ашиглагдаж, хэрэгжиж байгааг тодорхойлох зорилгоор нийт 80 байгууллагад (төрийн 51, хувийн 29) утсаар анхан шатны мэдээлэл авсан. Анхан шатны мэдээллийг мэдээллийн технологийн ажилтнуудыг хамруулсан фокус бүлгийн ярилцлагын аргачлалаар авч, байгууллагын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал болон сайжруулалтын боломжийг бодит нөхцөлд тулгуурлан тодорхойлов. Уг судалгааны үр дүн	100%

						дээр дүн шинжилгээ хийж боловсруулсан. Олон улсуудаас: Эстони улсын ХОУ-ын стратегийн судалгаа ХОУ-ын хууль эрх зүйн орчны харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэсэн. Дэлгэрэнгүй тайлан- Хавсралт 22	
7.4	Олон улсын байгууллагуудаас зарлагдсан тэтгэлэгт хөтөлбөр, сургалтын талаар судалгаа хийнэ.	-	Судалгааны тоо	-	1	- “И-Монгол академи” УТҮГ-ын албан хаагчдыг гадаад улсад сургалтад хамруулах, мэргэшил дээшлүүлэх зорилгоор олон улсын байгууллагуудаас зарлагдсан 13 тэтгэлэгт хөтөлбөр, сургалтын талаар судалгаа хийсэн, - Тайлант хугацаанд тус судалгаанд үндэслэн нийт 4 албан хаагчийг олон улсын тэтгэлэгт сургалтад амжилттай хамруулж, холбогдох бэлтгэл ажил, баримт бичгийн бүрдүүлэлтийг хийж, сургалтын дараах тайланг хүлээн авч танилцуулав. Мөн 2025–2026 онд зарлагдсан Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр болон 2026–2027 оны тэтгэлгийн мэдээллийг боловсруулан судалгааны тайлан бэлтгэсэн нь байгууллагын гадаад хамтын ажиллагааг төлөвлөх, тэтгэлэгт хөтөлбөрийн бодлогын чиглэлийг тодорхойлоход суурь мэдээллийн эх үүсвэр болсон. Дэлгэрэнгүй тайлан- Хавсралт 22	100%
7.5	Холбогдох нэгжүүдтэй хамтран олон улсын байгууллагаас хөрөнгө оруулалт татах ажлыг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан ажлын тоо	-	1	“Girls in ICT Mongolia” өдөрлөг зохион байгуулах ажлын хүрээнд Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн Сангаас (UNICEF) “Хамтран ажиллах, дэмжлэг хүсэх тухай” 01/186 дугаартай албан бичиг илгээж 7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт татсан; Дэлхийн банкны “Ухаалаг засаг” төслийн хүрээнд “Төрийн үйлчилгээний цахим шилжилт ба оролцогч талуудын бэлэн байдлын үнэлгээ” сэдэвт суурь судалгааг санхүүжүүлэхээр шийдвэрлэж, “И-Монгол академи” УТҮГ нь уг судалгааны төслийг	100%

						100,000 ам.доллороор хоёр үе шаттайгаар санхүүжүүлэх, нийт 200,000 ам.долларын төсвөөр хэрэгжүүлэхээр батлуулсан. Судалгааны Ажлын даалгавар (TOR)-ыг боловсруулж, Дэлхийн банк болон холбогдох талуудад албан ёсоор хүргүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Олон улсын байгууллагаас хөрөнгө оруулалт татах зорилгоор Дэлхийн банканд дараах төслүүдийг боловсруулж илгээсэн. Үүнд: 1. Төрийн үйлчилгээний систем “E-Mongolia”- г олон улсад танилцуулах, туршлага солилцох олон улсын хурал зохион байгуулах; 2. "Их Өгөгдлийн сан" үүсгэх, хэрэгжүүлэх төсөл; Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор ажилчдын тоног төхөөрөмж, компьютерыг шинэчлэх хөрөнгө оруулалтын төслүүдийг тус тус боловсруулж, илгээсэн. Энэхүү ажлын хүрээнд Дэлхийн Банкнаас ирүүлсэн худалдан авалтын журмын дагуу Бараа нийлүүлэх тендерийн урилга (Request for Bids – Goods) боловсруулж, илгээсэн. Дэлгэрэнгүй тайлан- Хавсралт 22	
7.6	Байгууллагын статистик мэдээллийг баяжуулах, хадгалах, мэдээллийн сан үүсгэнэ.	-	Статистик, мэдээллийн сантай болсон эсэх	-	1	Байгууллагын статистик мэдээллийг баяжуулах, хадгалах, мэдээллийн сан үүсгэх ажлын хүрээнд төлөвлөгөөг боловсруулан газар, хэлтсүүдээс холбогдох мэдээллийг цуглуулан onedrive дээр мэдээллийн сан үүсгэсэн. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 34.1.10-д заасны дагуу "Байгууллагын мэдээллийн сан ашиглах" журмын төслийг боловсруулж санал авч батлуулахаар ажиллаж байна. Дэлгэрэнгүй тайлан- Хавсралт 22 Байгууллагын статистик мэдээллийг баяжуулах, хадгалах, мэдээллийн сан үүсгэх төлөвлөгөө – Хавсралт 24 Байгууллагын статистик мэдээллийг баяжуулах, хадгалах, мэдээллийн сан үүсгэх ажлын тайлан - Хавсралт 25	100%

						“Төрийн албан хаагчдын ажил үүрэгт цахимжилт хэрхэн нөлөөлж буй” талаарх судалгааны асуулт боловсруулан нийслэл болон орон нутгийн төрийн байгууллагын холбогдох албан хаагчдаас авч судалгааг нэгтгэсэн. Судалгаанд нийт төрийн 86 байгууллага хамрагдсан. “И-Монгол академийн” захирлын 2025 оны А/22 тоот тушаалаар байгуулагдсан “Судалгааны үнэлгээ хийх” ажлын хэсгийн хүрээнд судалгааны ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл явцыг зохион байгуулж, судалгааны тайланг бүрэн хүлээн авсан. Уг судалгаа төрийн үйлчилгээг цахимжуулснаар төрийн албан хаагчийн ачаалалд нөлөөлсөн байдлыг бодитоор гаргаж ирэх, хүний нөөцийн зохион байгуулалт болон төрийн албан хаагчийн цахим ур чадвар зэргийг судалсан бодлогын баримт бичгийн суурь судалгаа юм. Дэлгэрэнгүй тайлан- Хавсралт 22 Төрийн үйлчилгээний цахимжуулалт төрийн албан хаагчдын ачаалалд нөлөөлсөн байдлын судалгаа – Хавсралт 26	
7.7	Төрийн үйлчилгээг цахимжуулснаар төрийн албан хаагчдын ачаалалд нөлөөлсөн байдлын судалгаа хийнэ.	19,000,000	Судалгааны тоо	-	1	“И-Монгол академийн” захирлын 2025 оны А/22 тоот тушаалаар байгуулагдсан “Судалгааны үнэлгээ хийх” ажлын хэсгийн хүрээнд судалгааны ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл явцыг зохион байгуулж, судалгааны тайланг бүрэн хүлээн авсан. Уг судалгаа төрийн үйлчилгээг цахимжуулснаар төрийн албан хаагчийн ачаалалд нөлөөлсөн байдлыг бодитоор гаргаж ирэх, хүний нөөцийн зохион байгуулалт болон төрийн албан хаагчийн цахим ур чадвар зэргийг судалсан бодлогын баримт бичгийн суурь судалгаа юм. Дэлгэрэнгүй тайлан- Хавсралт 22 Төрийн үйлчилгээний цахимжуулалт төрийн албан хаагчдын ачаалалд нөлөөлсөн байдлын судалгаа – Хавсралт 26	100%
7.8	Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын бэлэн байдлын судалгааны ажлын даалгавар боловсруулна.	19,000,000	Ажлын даалгаврын тоо	-	1	“И-Монгол академийн” захирлын 2025 оны А/22 тоот тушаалаар байгуулагдсан “Судалгааны үнэлгээ хийх” ажлын хэсгийн хүрээнд судалгааны ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл явцыг ахлан зохион байгуулж, судалгааны тайланг бүрэн хүлээн авсан. Дэлгэрэнгүй тайлан- Хавсралт 22 Төрийн үйлчилгээний цахимжилт ба оролцогч талуудын бэлэн байдлын үнэлгээний ажлын даалгавар - Хавсралт 27	100%

Товчилсон үгийн жагсаалт:

СНГ	Систем нэгтгэлийн газар
ЗХНГ	Захиргаа, хүний нөөцийн газар
СОНХГ	Сургалт, олон нийттэй харилцах газар
МАБГ	Мэдээллийн аюулгүй байдлын газар
ГХХАГ	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газар
ЦЗХ	Цахим засаглалын хэлтэс
САХ	Систем ашиглалтын хэлтэс
ХОТХ	Хиймэл оюуны туршилтын хэлтэс
МХ	Маркетингийн хэлтэс
СХ	Сургалтын хэлтэс
ХҮХ	Хэрэглэгчийн үйлчилгээний хэлтэс
СудХ	Судалгааны хэлтэс
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
ЗГҮАХ	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ҮДТ УТҮГ	Үндэсний дата төв УТҮГ

Тайлан хянасан:
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД
Тэмдэг

Төсвийн Ерөнхийлөн захирагч
..... (Э.БАТШУГАР)
.....
(огноо)

Тайлан гаргасан:
“И-МОНГОЛ АКАДЕМИ” УТҮГ-ЫН
ЗАХИРАЛ
Тэмдэг

Төсвийн шууд захирагч
..... (М.БАТТУЛГА)
.....
(огноо)